

**БАТЛАВ:**  
 НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН  
 ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГА  
 Ж.ГАНБОЛД

2017 оны 06 сар 30

Авилгын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх  
 арга хэмжээний төлөвлөгөө

2017 оны 06 дугаар сарын 30

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах эзэн	Хугацаа
Нэг. Хуулиар хүлээсэн үүрэг, удирдлага зохион байгуулалт, төрийн хяналт шалгалт төсвийн ил тод нээлттэй байдлыг хангах чиглэлээр			
1.	Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл тусламж, түүний хуваарьлалтыг хуулийн хугацаанд цахим хуудсанд тухай бүр мэдээллэх.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг хангана.	О.Эрдэнэцэцэг Н.Өлзийжаргал Жилдээ
2.	Тухайн жилийн төсөв, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг цахим хуудаст байршуулж нээлттэй мэдээлнэ.		
3.	Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Ил тод Улаанбаатар академи-Зөвлөлдөх ардчиллын танхим"-ын үйл ажиллагааг үргэлжлүүлэх.	Авлига, ашиг сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	А.Болдмаа Жилдээ
4.	Авилгын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээр шинээр гаргасан тогтоол, шийдвэр журмуудыг байгууллагын веб сайт, мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд сурталчилах.	Н.Өлзийжаргал	Тухай бүр
5.	Байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, орон тооны талаарх мэдээллийн өөрчлөлтийг тухай бүр байгууллагын сайтад байршуулан олон нийтэд нээлттэй сурталчилах.	Н.Өлзийжаргал	III улиралд
6.	Нийслэл дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагын ажилтнуудад авилгаас урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв мэдүүлэх, төрийн албан хэрэг хөтлөлт, төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар сургалт зохион байгуулах.	А.Болдмаа Н.Өлзийжаргал	IV улиралд
7.	Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг танилцуулж, мөрдлөгө болгон ажиллах.	А.Болдмаа А.Намуун	Жилдээ
8.	Байгууллагын удирдах албан тушаалтнуудаас		

	хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан авах.	А.Болдмаа	2017.02.1 0-ны дотор	
9.	Байгууллагын удирдлагаас гаргаж буй тушаал шийдвэрийн ил тод нээлттэй байдлыг хангах, цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан нийтэд мэдээллэх.	Н.Өлзийжаргал М.Цогзолмаа	Сар бүрийн 30-ны дотор	
10.	Хүний нөөцийн ил тод байдал, албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгож нийтэд ил байршуулах.	А.Намуун Н.Өлзийжаргал	III улиралд	
11.	Авилгын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачлагыг дэмжин хамтран ажиллах.	А.Болдмаа	Тухай бүр	
12.	Байгууллагын өргөдөл гомдлыг шийдвэрлэх ажлыг шуурхай боловсронгуй болгох, байгууллагын ажилтнуудад оноосон ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг ил тод болгох.	Н.Өлзийжаргал	Жилдээ	
13.	Худалдан авах үйл ажиллагааг цахимжуулж зарласан тендерийн талаарх мэдээллийг цахим хуудсанд тогтмол байршуулан Шилэн тендерийн тогтолцоонд шилжих.	Ж.Ганболд	Тухай бүр	
Хоёр. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын оновчтой бүтцийг бий болгох, албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх				
14.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнг "Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт" [KPI]-ээр үнэлж, хүний нөөцийн бүртгэл, хяналт, удирдлагын нэгдсэн санг бий болгох.	Улаанбаатар хотын хэмжээнд тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх, бүтээн байгуулалтын ажилд иргэдийн оролцоо, залуучуудын мэргэжил боловсрол, мэдлэг чадварыг татан оролцуулах зорилгоор "Нээлттэй ажлын байр" өдөрлөгийг зохион байгуулна.	Жилдээ С.Саранцэцэг	Өдөрлөг болох товлосон хугацаанд нь
15.	Төрийн захиргааны оновчтой бүтцийг бий болгох, ажлын уялдаа холбоог сайжруулах, төрийн албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, хариуцлагыг өндөржүүлэх, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн албыг хариуцлагатай, хяналттай, ухаалаг болгох.	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлж, дүүргийн зарим чиг үүргийг хороодод шилжүүлж, хороодоос үзүүлэх төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	М.Цогзолмаа Н.Өлзийжаргал	Жилдээ
16.	Ёс зүйн дүрмийн талаарх мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэх, зөрчлийн бүртгэл хөтлөх, хянан шийдвэрлэх хариуцлага тооцох.	А.Болдмаа	Тухай бүр	

17.	Байгууллагын албан хаагчидтай ашиг сонирхол зөрчлийн гэрээ байгуулах.	А.Болдмаа	III улирал
18.	Зөрчил үүссэн болон болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, ёс зүйн хорооны гишүүдийг чадваржуулах.	А.Болдмаа	Тухай бүр
19.	Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтод болон ажил үүргийн хуваарьт тусгах, хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтын байдал, тогтвортой ажиллах нөхцөлийг хангах.	А.Болдмаа С.Саранцэцэг	III улирал

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:

МЭРГЭЖИЛТЭН

*А. Намуун*

А.НАМУУН